

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Мөрөн нисэх буудал”-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/25/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн чанарын хяналт, ахлах аудитор: Н.Бадамханд
Утас: 99042699 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин.....	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.1 “Мөрөн нисэх буудал” ба түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	11
4. Аудитын тайлан.....	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал.....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
4.4.1 Шилэн дансны мэдээлэл.....	13
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
4.5.1 Завсрын аудитын талаар.....	13
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
5. Аудитын илрүүлэлт.....	13
5.1 Төлбөрийн акт.....	14
5.2 Албан шаардлага.....	14
5.3 Зөвлөмж.....	14
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлчилгээний газар



“МӨРӨН НИСЭХ БУУДАЛ”-ЫН ДАРГА
Д.ХИШИГБАТ ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.03.14 № 01/267
танай _____ -ны № _____ -Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мөрөн нисэх буудлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Мөрөн нисэх буудал”-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Мөрөн нисэх буудал” нь ИНЕГ-ын харьяа салбар байгууллага тул салбарын санхүүгийн тайлан бэлтгэж байна.

Аудитын гол асуудал

Шатахууны тооцоог хянахад анхан шатны баримт дутуу, бараа материал дансанд бүртгэхгүйгээр зарцуулсан 2721,900 мянган зөрчилд зөвлөмж хүргүүлэв

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Мөрөн нисэх буудал” нь 2022 онд 6 зорилтын хүрээнд 31 ажил төлөвлөсөн бөгөөд жилийн эцсийн байдлаар 87.7 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	320,890,650.39	206,579,431.97
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	44,949.24	13,690,221.87
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	44,949.24	13,690,221.87
3121	Төгрөг	44,949.24	13,690,221.87
31213	Арилжааны банк дахь харилцах	44,949.24	13,690,221.87
33	АВЛАГА	6,645,834.90	5,838,557.70
33401	Дансны авлага /ТӨҮГ/	6,645,834.90	5,838,557.70
35	БАРАА МАТЕРИАЛ	314,199,866.25	187,050,652.40
354	Хангамжийн материал	314,199,866.25	187,050,652.40
35420	Аж ахуйн материал	20,689,315.87	19,029,420.87
35430	Сэлбэг хэрэгсэл	4,821,007.08	3,673,520.88
35440	Түлш, шатах тослох материал	233,797,355.59	117,322,283.47
35470	Бусад хангамжийн материал	54,892,187.71	47,025,427.18
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,034,141,340.32	18,302,538,161.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,034,141,340.32	18,302,538,161.10
392	Биет хөрөнгө	5,153,201,778.96	6,398,008,038.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	11,045,069,292.25	12,024,538,373.45
39202	Хуримтлагдсан элэгдэл	-7,091,759,656.65	-7,367,599,624.15
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,276,123,384.72	1,086,805,113.29
39204	Хуримтлагдсан элэгдэл	-719,751,417.23	-543,716,119.95
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,909,180,362.78	3,509,335,523.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,279,114,485.98	-2,340,027,509.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	109,870,991.47	121,015,332.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-96,416,692.40	-92,343,050.80
393	Биет бус хөрөнгө	11,817,973,201.08	11,851,862,613.57
39301	Програм хангамж	75,110,893.62	109,610,893.62
39302	Хуримтлагдсан элэгдэл	-70,528,392.54	-71,138,980.05
39303	Бусад биет бус хөрөнгө	11,813,390,700.00	11,813,390,700.00
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	62,966,360.28	52,667,509.08
39403	Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/	62,966,360.28	52,667,509.08
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,355,031,990.71	18,509,117,593.07
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,355,031,990.71	18,509,117,593.07
51	Засгийн газрын хувь оролцоо	17,355,031,990.71	18,509,117,593.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11,813,390,700.00	11,813,390,700.00
51101	Өмч: - төрийн	11,813,390,700.00	11,813,390,700.00
512	Хуримтлагдсан үр дүн	4,461,396,402.67	4,175,106,601.74
51210	Өмнөх үеийн үр дүн	-	4,175,106,601.74
51220	Тайлант үеийн үр дүн	4,461,396,402.67	
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,080,244,888.04	2,520,620,291.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	17,355,031,990.71	18,509,117,593.07

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

		/төгрөгөөр/	
Мөр	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	2,452,792.01	57,221,934.40
2	Борлуулалтын өртөг	1,991,648,942.17	1,941,667,647.55
3	Нийт ашиг (алдагдал)	-1,989,196,150.16	-1,884,445,713.15
4	Түрээсийн орлого	0	221,272.73
8	Бусад орлого	1,839,151,947.81	1,856,071,243.96
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,700,163.64	2,500,000.00
12	Бусад зардал	79,348,329.45	250,620,592.99
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0	-5,016,011.48
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-232,092,695.44	-286,289,800.93
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-232,092,695.44	-286,289,800.93
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-232,092,695.44	-286,289,800.93
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-232,092,695.44	-286,289,800.93

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

						/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				0.00	
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00	
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	
C07	Тайлант үеийн үр дүн				0.00	
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,813,390,700.00	1,080,244,888.04	4,461,396,402.67	17,355,031,990.71	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00	
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,813,390,700.00	1,080,244,888.04	4,461,396,402.67	17,355,031,990.71	
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		1,440,375,403.29		1,440,375,403.29	
D08	Тайлант үеийн үр дүн			-286,289,800.93	-286,289,800.93	
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,813,390,700.00	2,520,620,291.33	4,175,106,601.74	18,509,117,593.07	

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,549,070,666.99</u>	<u>1,532,851,849.21</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,760,666.99	25,564,549.21
120	Нийтлэг татварын бус орлого	24,760,666.99	25,564,549.21
120009	Бусад орлого	24,545,137.00	2,101,100.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	215,529.99	17,668,505.21
120015	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө /ТӨҮГ/	-	5,794,944.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,524,310,000.00	1,507,287,300.00
1330	Төсвийн захирагчдаас	1,524,310,000.00	1,507,287,300.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,524,310,000.00	1,507,287,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,543,471,553.40</u>	<u>1,515,206,576.58</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,543,471,553.40	1,515,206,576.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,543,471,553.40	1,515,206,576.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	812,390,091.79	782,168,602.12
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	812,390,091.79	782,168,602.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	247,622,568.83	232,577,292.82
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	247,622,568.83	232,577,292.82
2103	Байр ашиглалттай холбоотой өсөлт, бууралт зардал	44,350,027.97	47,337,717.28
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	44,350,027.97	47,337,717.28
2104	Хангамж, бараа материалын зардал	211,310,780.00	226,409,232.50
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	114,535,470.00	143,469,983.50
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	96,775,310.00	82,939,249.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	227,798,084.81	226,713,731.86
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	165,330,313.21	165,279,764.86
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/		31,243,987.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	62,467,771.60	30,189,980.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,599,113.59</u>	<u>17,645,272.63</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	23,931,000.00	4,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,931,000.00	4,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	23,931,000.00	4,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	4,000,000.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	23,931,000.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>23,931,000.00</u>	<u>4,000,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	13,645,272.63
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,376,835.65	44,949.24
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	44,949.24	13,690,221.87

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Зардлын нэр, эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв		Төсвийн гүйцэтгэл		Хэтрэлт/-/, хэмнэлт /+/ /мянган төгрөг/	
		зардал	Орлого	зардал	Орлого	Зөрүү	хувь
1	Буулт хөөрөлтийн орлого/ Дотоодын авиа компани орон нутаг/	0	300.00		5,120.0	(4,820.0)	-1607%
2	Зорчигч үйлчилгээний хураамж /орон нутаг/		100.00		1,936.6	(1,836.6)	-1837%
4	Газрын техник үйлчилгээний орлого				8,321.4	(8,321.4)	
5	Шатахууны сумалгаа, хадгалалтын орлого				705.8	(705.8)	
6	Үйл ажиллагааны бусад орлого		1,500.00		42,163.7	(40,663.7)	-2711%
9	ИНҮТ-ээс санхүүжилт				1,510,101.2		
10	Систем хоорондын тооцоогоорх орлого				306,603.2		
11	Үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөн орлого				38,562.6		
	Цалин хөлс	1,119,764.8		931,359.7	-	188,405.1	17%
12	Үндсэн цалин	985,597.0		806,364.7		179,232.3	
13	Нэмэгдэл			-		-	
14	Унаа хоолны хөнгөлөлт	134,167.8		124,995.0		9,172.8	
15	Урамшуулал			-		-	
16	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,970.5		127,131.0	-	12,839.5	9%
17	Тэтгэврийн даатгал-8.5	95,180.0				95,180.0	
18	Тэтгэмжийн даатгал-1	11,197.6				11,197.6	
19	ҮОМШӨ-ний даатгал-1.8	8,958.1				8,958.1	
20	Ажилгүйдлийн даатгал-0.2	2,239.5				2,239.5	
21	Эрүүл мэндийн даатгал-2	22,395.3				22,395.3	
22	Гэрэл, цахилгаан	65,148.6		49,779.5		15,369.1	24%
23	Түлш, халаалт	36,604.1		30,951.0		5,653.1	15%
24	Цэвэр, бохир ус	2,149.0		328.8		1,820.2	85%
25	Бичиг хэрэг	1,741.3		2,232.4		(491.1)	-28%
26	Тээвэр, шатахуун	69,281.9		56,228.9		13,053.0	19%
27	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	7,165.4		6,854.2		311.2	4%
28	Цэвэрлэгээний зардал	9,207.8		8,940.0		267.8	3%
29	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,535.0		2,758.2		1,776.8	39%
30	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,310.0		7,674.4		11,635.6	60%
32	Сэлбэг хэрэгсэл- Барилга	37,310.0		8,501.3		28,808.7	77%
33	Сэлбэг хэрэгсэл- Тоног төхөөрөмжийн	48,317.5		42,470.9		5,846.6	12%
34	Сэлбэг хэрэгсэл- Автомашин	15,623.5		15,207.8		415.7	3%
35	Сэлбэг хэрэгсэл- Аэродром	39,065.0		18,871.5		20,193.5	52%
36	Гал унтраах зардал	21,925.0		14,274.5		7,650.5	35%
37	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	16,388.3		12,252.7		4,135.6	25%
38	Дотоод албан томилолт	21,735.2		19,378.6		2,356.6	11%

39	Харуул хамгаалалтын зардал	4,600.0		1,237.2		3,362.8	73%
41	Үл хөдлөх хөрөнгийн татвар	74,524.0		75,288.4		(764.4)	-1%
42	Дотоод сургалт	3,770.0		1,517.6		2,252.4	60%
43	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,362.0		3,403.7		(41.7)	-1%
44	Даатгалын үйлчилгээ	25,124.0		25,123.8		0.2	0%
45	Тээврийн хэрэгслийн татвар	774.0		757.5		16.5	2%
46	Газрын төлбөр	15,594.6		15,406.6		188.0	1%
47	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	240.0		117.8		122.2	51%
48	Бараа үйлчилгээний бусад зардал	4,550.0		1,641.1		2,908.9	64%
51	Буцалтгүй тусламж	11,500.0		8,679.3		2,820.7	25%
	Эмчилгээний төлбөр	8,300.0		8,300.0		-	0%
52	Систем хоорондын тооцоогоорх зардал			233,523.5		(233,523.5)	
53	Үндсэн хөрөнгийн элэгдэл			535,488.8		(535,488.8)	
54	Үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөн зарлага			5,016.0		(5,016.0)	
Дүн		1,827,581.5	1,900.00	2,270,696.7	1,913,514.5	(443,115.2)	-24%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 “Мөрөн нисэх буудал” ба түүний үйл ажиллагаа

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Байгууллага нь нийт 40 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын эрхэм зорилго: “Олон улсын зэрэглэл бүхий баруун болон төвийн бүсийн агаарын тээврийн болон зорчигч үйлчилгээний хүчирхэг зангилаа болох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл, зорилтоо тодорхойлсон байна.

- Зорчигч тээврийн үйлчилгээ
- Иргэний нисэхийн ерөнхий газрын стратеги зорилтыг хангахад чиглэсэн ажил үйлчилгээ
- Нисэх буудлын аюулгүй байдлыг хангах чиглэлээр
- Аэродромын бэлэн байдлыг хангах чиглэлээр
- Агаарын навигаци тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах чиглэлээр тус тус ажиллаж байна.

Ииргэний нисэхийн ерөнхий газарт салбаруудын санхүүгийн тайлан, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланг нэгтгэн гаргадаг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Мөрөн нисэх буудал нь байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дараах хууль тогтоомж, бодлого, журмыг мөрдөж байна.

- Аюулгүй ажиллагааны менежментийн тогтолцооны стандарт
- Үйл ажиллагааны заавар
- Төсвийн тухай хууль
- Иргэний нисэхийн тухай хууль
- Төрийн өмч хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах

- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль
- Иргэний нисэхийн багц дүрмүүд

Иргэний нисэхийн ерөнхий газрын дэргэдэх Дотоод аудит дотоодын хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөрөн нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу иж бүрэн бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Мөрөн нисэх буудал нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ИНЕГ-ын даргын А/124 дугаар тушаалаар 2021 оны 10 дугаар сарын 21-ны өдөр шинэчлэн баталсан байна.

Байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэдэг ба бараа материалыг эхэлж зарлагадах аргаар бүртгэж тайлагнадаг.

Санхүү бүртгэл тооцоогоо санхүүгийн тооцоолох компаниас гаргасан удирдлагын нэгдсэн цогц программ "Veritech ERP" программыг ашиглаж байна.

Мөрөн нисэх буудлын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,154.1 сая төгрөгөөр буюу 6.6 хувиар өсөж 18,509.1 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.04	13.7	13.6
Авлага	6.6	5.8	(0.8)
Бараа материал	314.2	187.1	(127.1)
Үндсэн хөрөнгө	17,034.1	18,302.5	1,268.4
Биет бус хөрөнгө	11,818.0	11,851.9	33.9
Нийт хөрөнгө	17,335.0	18,509.1	1,154.1
Өр төлбөр	-	-	-
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	17,335.0	18,509.1	1,154.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	17,335.0	18,509.1	1,154.1

Дээрх өөрчлөлтөд дараах зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө данс тайлант онд 13.6 сая төгрөгөөр өсөн байна.
- Авлага дансны үлдэгдэл буурсан нь Аэро Монгол ХХК-аас 2020, 2021, 2022 онд үүссэн 6.6 сая төгрөгийг авлагыг бүрэн барагдуулснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2022 онд үүссэн 5.8 сая төгрөгийн “ХҮННҮ ЭЙР” ХХК болон “СКАЙЖЕТ” ХХК “Монгол” ХХК-аас /буулт хөөрөлт, газрын үйлчилгээний төлбөрт үйлчилгээний авлага/ авлага байна. Үүнээс бүгд 2023 оны 1-р улиралд багтаан барагдуулах боломжтой авлага юм.
- Бараа материалын дансны үлдэгдэл 187.1 сая төгрөг болж өмнөх оноос 127.1 сая төгрөгөөр өссөн нь ИНЕГ-аас нөөцийн ТС шатахуунд хангалт хийгээгүй аймаг хооронд шилжүүлснээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд нөөцийн шатахуун 117.3 сая төгрөгийн бусад хангамжийн 69.7 сая төгрөгийн материал байна.
- Үндсэн хөрөнгийн данс 1,268.4 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгийн дахин үнэлгээг хийсэнтэй холбоотой байна. Хөрөнгө оруулалтаар 224,5 сая төгрөг, өөрийн урсгал зардлаас худалдан авсан 5.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, салбар хооронд дотоод хөдөлгөөнөөр 39.2 сая төгрөг, БОАЖЯамны хөрөнгөөр 39.6 сая төгрөгөөр заал тохижилтын ажил тус бөгөөд 2022 хийгдэж хөрөнгө нэмэгдсэн байна.

3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу байгууллагын гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Мөрөн нисэх буудлын 2022 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,827.6 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр 1,913.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,270.7 сая төгрөгийн зардал гарган, 357.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Мөрөн нисэх буудал нь тайлант 2022 онд 1.9 сая төгрөгийн орлого төлөвлөснөөс гүйцэтгэлээр 16.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 847 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

дд	Үзүүлэлт	2022			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл				
	Буулт хөөрөлтийн орлого	0.3	5.1	4.8	160.7
	Зорчигч, газрын үйлчилгээний хураамж	0.1	10.3	10.4	
1	Шатахуун сумалгаа, хадгалалтын орлого	-	0.7	0.7	
	Үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөн орлого	-	38.6	38.6	
	ИНҮТ-ээс санхүүжилт	-	1,510.1	1,510.1	
	Систем хорондын тооцоогоорх орлого	-	306.6	306.6	
2	НИЙТ ОРЛОГО	1.9	1,912.8	1910.9	
3	НИЙТ ЗАРДАЛ	1,827.6	2,270.7	443.1	124.0
4	Татварын өмнөх ашиг	-232.1	-286.3	(73.5)	(198.0)
5	Цэвэр ашиг /алдагдал/	-232.1	-286.3	(71.2)	(220.3)
8	Нийт ажиллагсдын тоо	40	40	-	100.0
9	Нийт цалингийн сан	1,119.8	931.6	(188.4)	117.0
15	НИЙТ АВЛАГА	6.6	5.8	(0.8)	87.8
16	НИЙТ ӨГЛӨГ	-	-	-	-
	Үүнээс: Богино хугацаат	-	-	-	-

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мөрөн нисэх буудлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зардлын данстай холбоотой, гэрээ хэлцлийн талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Мөрөн нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайланг Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 41.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 29.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудасны мэдээллийг бүрэн мэдээллэсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 1,564.0 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илрүүлж аудитын хугацаанд залруулан ажилласан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 46.2 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн байна. Тайлант онд зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
				Хувь	
Зөвлөмж	2	46.2	2	46.2	100
Нийт дүн	2	46.2	2	46.2	100

/сая төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,564.2 сая төгрөгийн алдаа илэрснээс, аудитын явцад 1,564.2 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын 9 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болсон үр дүнгийн тайлан, үндсэн хөрөнгийн хураангуй тайланд туссан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал зөрүүтэй байсныг залруулав.
- 2021 оны үр дүнгийн тайланд санхүүжилтийн тайланд ИНЕГ-аас авсан санхүүжилтийг борлуулалтын орлогоор тайлагнасан байсныг санхүүжилтийн орлогыг борлуулалтын орлогоос салгаж үнэн зөв тайлагнаж залруулга хийсэн.
- Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын 9 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болсон санхүүгийн байдлын тайланд авлагын үлдэгдэл 21.4 төгрөг болж өмнөх оноос 14.8 төгрөгөөр нэмэгдсэн тул завсрын аудитаар зөвлөмж өгч, аудитын хугацаанд зөвлөмжийн биелэлтийг ханган, авлагыг өмнөх оноос буруулсан байна.

Аудитаар нийт 2.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 2.7 сая төгрөгийн зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материал дансанд ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр 2.4 сая төгрөгийг орлого зарлагаар бүртгэхгүйгээр, шууд олгосон талоноор зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 13.1 заалтыг хэрэгжүүлээгүй ба “үнэлгээ ба хэмжилт” батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Бараа материал дансанд ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээ, орлого зарлагаар бүртгэж байх.

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахууны тооцоог шалгахад анхан шатны баримтын бүрдэл дутуу 0.3 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн, эрх үүрэг, тохиолдсон байх, үнэн зөв байх зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг хийхдээ анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал зөрүүтэй	1	0.2			1	0.2	1	0.2				
Санхүүжилтийг борлуулалтын орлогоор тайлагнасан	1	1,549.1			1	1,549.1	1	1,549.1				
Авлага үүсгэсэн	1	14.9			1	14.9	1	14.9				
Нийт	3	1,564.2			3	1,564.2	4	1,564.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар бүртгэхгүйгээр, шууд олгосон талноор зардалд бүртгэсэн	1	2.4					1	2.4				
Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн	1	0.3					1	0.3				
Нийт	2	2.7					2	2.7				

АУДИТЫН ТАЙЛАНГ:
ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Б.ДАВААНЯМ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

ЧАНАРЫН ХЯНАЛТ, АУДИТОР

Х.ДИЙМАА

Н.БАДАМХАНД

